



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16

E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019. 10. 08 № 22

Асуулга тавих тухай

Цаг агаарын урьдчилсан мэдээгээр ирэх өвөл манай улсын уулархаг нутгаар цас их орж цасан шуурга шуурах, ялангуяа 10, 11 дүгээр саруудад баруун болон төвийн бүсийн нутгаар цас, бороо холилдон орох, хөрс хөлдөх зэргээс үүдэн малын бэлчээрлэлт болон малчдад ноцтой хүндрэл учирч болзошгүй байна.

Иймээс өвлийг өнтэй давах асуудалд эртнээс анхаарал хандуулж, байнгын бэлтгэлтэй байх, мах бэлтгэлийн ажлыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч буй тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Сүүлийн үед мах, махан бүтээгдэхүүний үнэ, нийлүүлэлтийн асуудал олон нийтийн дунд багагүй бухимдал төрүүлж байна. БНХАУ-ын иргэнд аж ахуйн нэгжүүд хямд үнээр их хэмжээний мах худалдан авч нөөцөлж буй нь эргээд махны зохиомол хомсдол үүсгэн, үнийн хөөрөгдөл бий болгож, дотоодын махны үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж буй талаар иргэд шүүмжилсээр байна. Тиймээс малчид болон хот суурин газрын иргэдийн аль алины эрх ашгийг хохироохгүй байх, махны экспорт, худалдаа, нөөцлөлтийн талаар Засгийн газраас ямар зохицуулалт хийж буй талаар;
2. Энэ жил улсын хэмжээнд нийт 169.7 мянган малчин өрхөд 67.7 сая мал өвөлжинө. Хөдөө орон нутагт отор нүүдэл хийхэд бэлчээрийн хомсдол бий болж, орон нутгийн удирдлага, иргэдийн хооронд өтөг бууц, бэлчээртэй холбоотой маргаантай асуудал үүсч байна. Тиймээс отроор өвөлжиж, хаваржихад Засгийн газар, салбарын яам ямар зохицуулалт хийж байгаа болон бэлчээрийн даац жилээс жилд муудаж байгааг хэрхэн зогсоох талаар;
3. Аймаг, сумын аюулгүйн нөөцөд 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 30.8 мянган тонн өвс, 12.1 мянган тонн тэжээл бэлтгэхээс 2.8 мянган тонн өвс, 1.2 мянган тонн тэжээл бэлтгээд байгаа нь өвсний 9.4 хувь, тэжээлийн 10.1 хувийг эзэлж хангалтгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар;

4. Малчдын эрүүл мэндийн асуудал, 0-2 насны вакцинд хамрагддаг хүүхэд, жирэмсний болон эмчийн хяналтанд байдаг эх, хүнд өвчтэй хүмүүсийг онцгойлон анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал, малаа даган өөр аймаг, сумын нутагт өвөлжих иргэдийн эрүүл мэндийн асуудалд хэрхэн анхаарч ажиллах вэ? Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эмийн нөөц, шатахуун гэх зэрэг шаардлагатай зүйлсийн бэлтгэл ажил, төсөв хөрөнгийн хэрхэн шийдвэрлэсэн талаар;
5. Өвөлжилт хүндэрч, хөдөө орон нутаг руу өвс, тэжээл болоод бусад тусламж хүргэх гэнэтийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд онцгой байдлын алба, албан хаагчид бэлэн эсэх, тэдний хувцас, техник, тоног төхөөрөмжийн хангалт хэр байгаа талаар;

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсохыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.БЯМБАЦОГТ